



**МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр,
Утас: 31 06 12, 7600 3333-1126, Факс: (976-11) 32 29 04,
И-мэйл: info@mcud.gov.mn, Вэбсайт: www.mcud.gov.mn

2020.04.08 № 03/1254

танай _____-ны № _____-т


АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ

“Коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон сууц, нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудад авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 2020/04 дүгээр албан даалгаврыг Танд үүгээр хүргүүлж байна.

Барилга, хот байгуулалтын сайдын албан даалгаврыг тухайн нутаг дэвсгэрт орон сууц, нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудад танилцуулж, хэрэгжилтийг хангах талаар онцгой анхаарч, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт ...3... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



С.МАГНАЙСҮРЭН

151061166

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 4 сарын 08 өдөр

Дугаар 2020/04

Улаанбаатар хот

Коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон сууц, нийтийн аж ахуйн салбарын байгууллагуудад авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Олон улсад коронавируст халдварт өвчин тархаж Онцгой нөхцөл байдал үүсээд байгаатай холбогдуулан зарим улсын цэвэрлэх байгууламж, бохир усны цооногоос коронавирусын халдвар илэрсэн байна.

Монгол Улсын Шадар сайд, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 08 дугаар тушаалаар баталсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээ шуурхай зохион байгуулах журам”-ын дагуу мэргэжлийн байгууллагуудын түргэвчилсэн үнэлгээгээр халдвар тархах эрсдэл манай улсад “маш өндөр” түвшинд гэж тогтоогдсон байна.

Иймд энэхүү онцгой нөхцөл байдалтай холбогдуулан орон сууцны барилга байгууламжийн болон ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээний чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигчид (хуулийн этгээд)-д коронавируст халдвар тархах болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хэрэгжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог хангах, үйлдвэрлэлийн талбайд ажиллаж байгаа иргэн, ажилтны амь нас, цаашлаад нийгмийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, улсын онцгой комиссын шийдвэр, мэргэжлийн байгууллагуудын гаргасан зөвлөмжийн хүрээнд, цаг үеийн нөхцөл байдалд нийцүүлэн шуурхай авч хэрэгжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн Засаг дарга болон Аймаг, нийслэлийн Орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагын дарга /захирал/ нарт ДААЛГАХ нь:

Нэг. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

1.1. Орон сууц, нийтийн аж ахуйн ашиглалт, үйлчилгээний байгууллагуудад коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг үе шаттай зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах;

1.2. Нэн тэргүүнд тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрт коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бохир усны ашиглалт, үйлчилгээний дараах чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигч (хуулийн этгээд)-ийг хамруулан зохион байгуулах. Үүнд:

1.2.1. бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээ;

1.2.2.бохир ус татан зайлуулах шугам сүлжээний болон бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээ;

1.2.3.бохир усыг тусгай зориулалтын авто машинаар зөөвөрлөх үйлчилгээ.

1.3. Бохир усны шугам сүлжээ болон цэвэрлэх байгууламжид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хэрэгжүүлэхэд, түүнд тавих хяналтыг сайжруулах;

1.4. Ажиллагсдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх хувцас хэрэгслээр хангах, шаардлага хангасан амны хаалт байнга хэрэглэх талаар холбогдох чиглэл өгч, өөрийгөө халдвараас урьдчилан сэргийлэх сургалтад хамруулах;

1.5. Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж болон бусад аймаг, орон нутаг дахь цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн ус гол руу шууд цутгах, ил задгай хаягдах хэсэгт коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх хяналт, тандалт хийх;

1.6. Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийн гаргалгааны суваг дахь усанд коронавируст халдвар урьдчилан сэргийлэх, илрүүлэх шинжилгээ хийх;

1.7. Цэвэрлэх байгууламжид халдваргүйтгэл хийхэд зайлшгүй шаардлагатай бодисоор хангах, нөөц бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

1.8. Хот, суурин газрын айл өрхийн бохирын цооног, нүхэн жорлонд ариутгал, халдваргүйтгэл хийх ажлыг үе шаттайгаар тасралтгүй байлгах;

1.9. Ил задгай бие засах байдлыг зогсоох талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, хандлагыг нь өөрчлөх, соён гэгээрүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

1.10. Коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх нөхцөл байдалтай холбоотой улсын онцгой комисс, шуурхай штаб, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэр, мэдээ, мэдээлэл, заавар, зөвлөмжийг Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тухай бүр шуурхай мэдэгдэх;

1.11. Бохир усны ашиглалт, үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар холбогдох мэдээллээр хангаж, хамтран ажиллах.

Хоёр. Аймаг, нийслэлийн Орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагын дарга /захирал/ нарт:

2.1. Байгууллагын хэмжээнд коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх тусгайлсан төлөвлөгөө баталж, хэрэгжүүлж ажиллах;

2.2. Бохир усны шугам сүлжээ болон цэвэрлэх байгууламжид ажиллагсдын ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдөр тутмын

зааварчилгаанд коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар тусгаж мөрдүүлэх;

2.3. Үйлдвэрлэлийн /ажлын/ талбайд хөдөлмөр эрхэлж буй иргэн, ажилтныг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрэн бүрдүүлэх;

2.4. Ажлын байрны ариутгал, хадваргүйтгэлийг тогтмол хийлгэх;

2.5. Ажиллагсдыг ажил үүрэгтэй тохирсон хувийн хамгаалалтын хэрэгсэл, амьсгалын зам болон бусад хэлбэрээр халдвар авахаас сэргийлж шаардлага хангасан амны хаалтыг тогтмол хэрэглүүлж хэвшүүлэх;

2.6. Байгууллагын дотоод нэгж /хэлтэс, алба, тасаг/ дэх нийт ажилтан, ажиллагсдын хамгаалах хэрэгсэлд үзлэг шалгалт хийх, мэргэжлийн байгууллагуудаас заавар, зөвлөмж авах;

2.7. Ариутгал, хадваргүйтгэл хийх тоног төхөөрөмжийн байнгын бэлэн байдлыг хангаж ажиллах;

2.8. Ариутгал, халдваргүйтгэл хийх бодисын бүрдүүлэлт, нөөцийг тасралтгүй байлгах;

2.9. Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, дархлааг дэмжих урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж ажиллах;

2.10. Холбогдох дээд байгууллагын шийдвэрт нийцүүлэн ажиллагсдыг ажлын онцлогоос хамааруулан өөрийн байгууллагын бага насны хүүхэдтэй эмэгтэй, өрх толгойлсон ажилчдыг богиносгосон цагаар болон зайнаас ажиллах боломжийг судалж шийдвэрлэх;

2.11. Улсын онцгой комисс, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг дагаж мөрдөх;

2.12. Монгол Улсын Шадар сайд, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 08 дугаар тушаалаар баталсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээ шуурхай зохион байгуулах журам”-ын дагуу халдвар орж ирсэн үед тархах эрсдэлийн үнэлгээг хийж 2020 оны 4 дүгээр сарын 25-ны дотор Барилга, хот байгуулалтын яаманд ирүүлэх;

2.13. Энэхүү албан даалгаварын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 2020 оны сар бүрийн 30-ны дотор Барилга, хот байгуулалтын яаманд ирүүлэх.

САЙД

Х.БАДЕЛХАН

